

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19, 20 ДАХЬ ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.4, 114.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 19, 20 дахь илтгэлийг хэлэлцээд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр дараах асуудалд анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:

а/Улсын онцгой комиссоос цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хүний эрх, эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт хийх аливаа шийдвэр гаргахдаа Хүний эрхийн Үндэсний Комиссоос санал авах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, Улсын онцгой комиссын хуралдаанд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг оролцуулж байх;

б/Улсын онцгой комисс болон эрх бүхий байгууллага гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг иргэн, олон нийт, нийгмийн бүлгүүдэд тэгш хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар тайлбарлах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллаж салбар хоорондын ажлын уялдааг сайжруулах;

в/нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, орон нутгийн онцгой комисс болон төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс халдвар авсан иргэнтэй хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхсан шинжтэй шийдвэрийг гаргаж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг ноцтой зөрчиж байгаа тул уг үйлдлийг таслан зогсоож холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцон ажиллах;

г/цар тахлаар өвдөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа болон гэрийн тусгаарлалтад байгаа иргэдэд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл дутмагаас шалтгаалан өвчин хүндрэх, амь нас нь эрсдэх аюулаас урьдчилан сэргийлэх, цар тахлын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжийг бүрдүүлэх;

д/халдвар авсан иргэдэд гэрийн тусгаарлалтад байх хугацаанд эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээг үнэн зөв, шуурхай хүргэх, өвчнийг эмчлэхэд шаардлагатай эмийн төрөл, хэрэглэх тун, заавар, мэдээллээр бүх иргэнийг тэгш, хүртээмжтэй хангах;

е/цар тахлын голомтод ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг эрсдэлийн болон амь насны даатгалд хамруулах, даатгалын нөхөх төлбөр авах, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэгийг тогтмол үзүүлэх асуудлыг судлан, холбогдох арга хэмжээг авч, цар тахлын голомтод ажиллаж байгаа төрийн албан хаагчдын илүү цагийн урамшуулал, голомтын бүсэд ажилласан хугацаанд онцгой нэмэгдлийг ердийн үеэс 2 дахин нэмэгдүүлсэн хувь хэмжээгээр тооцож олгох асуудлыг судлан шийдвэрлэх;

ё/цар тахлын үед иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр шуурхай, баталгаатай эдлүүлэх бүх боломж нөхцөлийг бүрдүүлж, халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эсэхээс үл хамаарч төрийн үйлчилгээ авах эрхийг хязгаарлахгүй байх;

ж/цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

з/цар тахлаас шалтгаалан ерөнхий боловсролын сургуулийн суурь хичээлүүдийг танхимаар судалж чадаагүй, сурч боловсрох эрх нь зөрчигдсөн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

и/баривчлах, саатуулах байранд байгаа иргэнийг халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээг авах эрхээр хангах.

2/Бусад асуудлаар:

а/бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт, зохиомол хомстол үүсгэж байгаа асуудлыг судлан, буруутай этгээдэд холбогдох хариуцлагыг тооцох, хилийн өртөөний ачаа эргэлтээс шалтгаалан бараа бүтээгдэхүүний үнийн зохиомол өсөлт нэмэгдэж, чингэлгийн бөөгнөрөл үүсч тээвэрлэлтийн зардал нэмэгдсэн нь иргэдийн амьжиргаанд нөлөөлж байгаа асуудлыг яаралтай судлан, шийдвэрлэх;

б/цар тахлын голомтод ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг аврах ажиллагааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх;

в/эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах, тоног төхөөрөмж, шаардлагатай бусад нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн